



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 03 өдөр

Дугаар А/588

Номгон

Г

Г

Мотоциклийн хөдөлгөөнийг түр  
хугацаагаар хориглох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Өвлийн улирал эхэлж, замын зорчих хэсгийн гадаргуу цасаар хучигдан халтиргаа гулгаа үүсч, авто замын нөхцөл байдал хүндэрсэн үед мотоциклоор замын хөдөлгөөнд оролцогчдын амь нас, эрүүл мэндийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, учирч болох хор хохирол эрсдэлийг багасах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт мотоциклтойгоор замын хөдөлгөөнд оролцохыг 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 01-нийг хүртэл түр хугацаагаар хориглосугай.

2.Иргэд, тээврийн хэрэгсэл эзэмшигч нарт Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай анхааруулга, сэрэмжлүүлэг өгч сурталчлах ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай хүргэж зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжүүлэн үр дүн, явц байдлын талаар болон хойшид авах арга хэмжээний саналыг танилцуулж байхыг Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн дэд хурандаа (Б.Мөнхбаяр)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Д.Сарангарав)-д даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

642311557